

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

№ 25/02

Г “Хорин хоёр дугаар бааз” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан 7
хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1 дахь заалтууд, компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.2.3 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих” журмыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурлыг 2025.04.30-ны өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот, 39-р хороо, Цагдаагийн академийн өргөн чөлөө өөрийн байрны 101 тоотод хуралдуулахаар тогтоосугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцэхээр багалсугай:
 1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайланг гүйцэтгэх захирал Т.Зоригтбаатар танилцуулах.
 2. Компанийн 2024 оны санхүүгийн тайланг ерөнхий нягтлан М.Нэргүй танилцуулах.
 3. Компанийн санхүүгийн тайланд хийсэн Аудитын дүгнэлт.
 4. Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах.
 5. Бусад.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04-р сарын 15-ны өдрөөр тасалбар болгосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тухай зарыг 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдөр өдөр тутмын сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр, 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр дахин мэдээлэх, Монголын хөрөнгийн биржийн сайтад тавих, брокерийн компанид хүргүүлэх зэргээр хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.
5. Хурлын зар өгөхтэй холбоотой зардлыг хурал зохион байгуулах комиссын дарга /З.ТУУЛ/-д гаргаж өгөхийг компанийн санхүүд даалгасугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахтай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь хавсралт 1-д заасан бичиг баримтыг БДК-иудаас авч танилцах эрхтэй болохыг дурдсугай.
7. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс энэхүү хурлаар хэлэлцэх асуудлаар саналын хуудсаар санал авах “саналын хуудас”-ын агуулгыг хавсралт 2-г зааснаар баталсугай.
8. Компанийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлаар санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 14:00 цагаар тасалбар болгосугай.
9. Тогтоолын хэрэгжилтийг хангах, ажлыг зохион байгуулах үүрэг бүхий хурал зохион байгуулах бөгөөд тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

- Б.Мөнгэрэл дарга
- Т.Халиун гишүүн

10. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
11. Хурал хуралдуулах тухай тогтоолыг гаргаснаас хойш 3 хоногийн дотор “22-р Бааз” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг хавсралт 3-д заасан маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргэхийг хурал зохион байгуулах комиссын дарга /З.Туул/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.ГҮНДЭГМАА